



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/194

Хэрлэн сум

Цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.2, 66.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудын үйл ажиллагаа эрхлэх шинэчилсэн цагийн хязгаарыг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэх цагийн хязгаарын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Дэд хурандаа Э.Жавхлантөгс), Сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийг холбогдох хууль, журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын цагийн хязгаар” тогтоох тухай А/510 дүгээр захирамжыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010488



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЦАГИЙН ХЯЗГААР

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Цагийн хязгаар
1.	Согтууруулах ундаа худалдах	08:00-00:00
2.	Согтууруулах ундаагаар үйлчлэх	11:00-22:00
3.		14:00-04:00